

ГАРЧИГ

НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА..4	
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....5	
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... 16	
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... 16	
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... 18	
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... 19	
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..... 19	
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....20	
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....24	
АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....28	
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....34	
ДҮГНЭЛТ.....35	

ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт.....	4
Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	5
Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	19
Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	20

ЗУРГИЙН ГАРЧИГ


Зураг 1. Төслийн байршлын зураг.....	4
Зураг 2. Уурхайн зам талбайд усалгаа хийх явц.....	6
Зураг 3. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан мод.....	7
Зураг 4. Ус ашиглуулах дүгнэлт.....	8
Зураг 5. Ус ашиглуулах дүгнэлт.....	9
Зураг 6. Ус ашиглуулах дүгнэлт.....	10
Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт.....	11
Зураг 8. Ус ашиглуулах гэрээ.....	12
Зураг 9. Ус ашиглуулах гэрээ.....	13
Зураг 10. 2025 оны ус ашигласны төлбөр төлсөн баримт.....	14
Зураг 11. Уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал.....	15
Зураг 12. Шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал.....	16
Зураг 13. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээлгэн өгсөн акт.....	17
Зураг 14. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээлгэн өгсөн акт.....	18
Зураг 15. Уурхайн талбай дахь галын булан.....	19
Зураг 16. Өлзийт сумын ЗДТГ-тай байгуулсан “Хог хаягдлын гэрээ”.....	21
Зураг 18. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх үйл явц.....	23
Зураг 19. Хог хаягдлын түр хадгалах ангилан ялгах цэг.....	23
Зураг 20. Хөрсний дээж авч буй байдал.....	24
Зураг 21. Агаарын чанарын хэмжилт болон усны дээж авч буй байдал.....	24
Зураг 22. Усны шинжилгээний дүн.....	25
Зураг 23. Хөрсний шинжилгээний дүн.....	26
Зураг 24. Агаарын чанарын шинжилгээний дүн.....	27
Зураг 25. Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан байдал.....	28
Зураг 26. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай.....	29
холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив,.....	29
тусламж өгөх чиглэлээр хамтран ажилах гэрээ.....	29

Зураг 27. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай.....	30
холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив,	30
тусламж өгөх чиглэлээр хамтран ажилах гэрээ	30
Зураг 28. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай.....	31
холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив,	31
тусламж өгөх чиглэлээр хамтран ажилах гэрээ	31
Зураг 29. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай.....	32
холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив,	32
тусламж өгөх чиглэлээр хамтран ажилах гэрээ	32
Зураг 30. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай.....	33
холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив,	33
тусламж өгөх чиглэлээр хамтран ажилах гэрээ	33
Зураг 31. Хамтран ажилах гэрээний биелэлт.....	34

НЭГ. 2025 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр:	“Шарангатай” нэртэй хайлууур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“ТЕРРА ВИСТА” ХХК. Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22-р хороо, Төгөл хаус, 12-1 тоот.
Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:	MV-022056 тусгай зөвшөөрөл бүхий “Шарангатай” хайлууур жоншны орд нь засаг захиргааны хувьд Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт харьяалагдах ба Улаанбаатар хотоос урагш хатуу хучилттай замаар 356 км-т Дундговь аймгийн Хулд сум хүрэх ба зүүн тийш 36 км-т байрлана.
Төсөл хэрэгжүүлэгч байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:	Улсын бүртгэлийн гэрчилгээ ✓ Улсын бүртгэлийн дугаар: 9011554003 ✓ Регистрийн дугаар: 5968216 Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл ✓ Дугаар: MV-022056



Зураг 1. Төслийн байршилын зураг

2025 онд уулын ажлын календарчилсан төлөвлөгөөндөө хүрч ажиллаж чадаагүй бөгөөд 10-р сарын 31-ний байдлаар 10.0 мян.тн хүдэр олборлосон болно.


ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөллүүд	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал, мян.төг	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Агаар орчин				
Уурхай орчимд тоосжилт үүсэх	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах, дагтаршуулах	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардлаас	Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн.
	Жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, орчин дахь тоосны хэмжээг тодорхойлж байх	Жилд 2 удаа	ОХШХ-ийн зардлаас	ОХШХ-ийн дагуу хяналт шинжилгээг хийлгэсэн.
Гадаргын ба газрын доорхи усны нөөц				
Ашиглаж буй усны чанар муудах, хүрэлцээ бага байх	Ус ашигласны төлбөрийг цаг тухайд нь тогтмол хугацаанд төлөх	Үйл ажиллагааны турш	Үйл ажиллагааны зардлаас	Ус ашигласны төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлсөн
	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Улиралд 1 удаа	Үйл ажиллагааны зардлаас	ОХШХ-ийн хүрээнд шинжилгээ хийлгэсэн.
Хөрсөн бүрхэвч				
Төслийн үйл ажиллагааны явцад ихээхэн талбайн хөрс овоолго, уурхайн тосгон, бусад байгууламжуудын дор дарагдаж, элэгдэл, эвдрэлд өртөнө.	Овоолго болон бусад байгууламжуудыг байгуулахын өмнө өнгөн хөрсийг хуулан авах,	Ашиглалтын явцад	Үйл ажиллагааны зардлаас	Шимт хөрсний овоолго үүсгэн хадгалсан.
	Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах			
Уурхайн замын ачааллаас хөрс элэгдэж, эвдрэлд орох	Хүнд машин механизм явах замыг засаж сайжруулан, байгалийн хөрс бүхий замаар тээвэрлэлт аль болох бага хийх	Ашиглалтын явцад	-	Уурхайн зам талбайг тогтмол услан чийгшүүлж, зам арчилгааг тогтмол хийж гүйцэтгэсэн.
Ургамлан нөмрөг				
“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн талбай болон орон нутгаас сонгосон талбайд мод тарих	Уурхайн тосгон орчим	100 ш	10 000.0	Уурхайн талбай орчимд 100 ш мод суулгасан
Амьтны аймаг				
Амьтны аймагт хохирол учруулах, тоо толгой хорогдох, идэш тэжээлийн хомсдол үүсэх	Мал амьтан өнгөрч гардаг хэсгүүдэд тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах, Авто машины хурдыг тогтоосон хязгаарт байлгах	Ашиглалтын явцад	Үйл ажиллагааны зардлаас	Уурхайн тээврийн зам дагуу тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан.




Зураг 2. Уурхайн зам талбайд усалгаа хийх явц



Зураг 3. “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тарьсан мод

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш мод тарьж, хашаажуулсан болно.

**Умард говийн гүвээт-Халхын дундад талын**
УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 12 -р сарын 26 -ны өдөр

Дугаар Е-2512-000169

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Терра виста ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 5968216
Захирал: Хасда
Холбоо барих дугаар: 91918339
Факс :
И-мэйл хаяг :

2.Төслийн нэр байршил

Төслийн нэр: Шарангатай нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах
Байршил: Дундговь, Өлзийт, 4-р баг, Дэрт 1
Харьяалагдах сав газар: Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар
Хамаарах салбар: Уул уурхай
Төслийн дэлгэрэнгүй: Жилд 40.0 мян.тн хүдэр олборлоно.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Терра виста

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
5	1 ээлжээр	160	25	10

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	87.0	хоногт 1 хүн	2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд жилд ажиллах хоног 180 хоног байхаар тусгасан байна. Маягт-12 ажиллах хүний тоо 87 байна.
Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд	200.0	ш	2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 200 ширхэг мод тарихаар тусгасан байна.

Зураг 4. Ус ашиглуулах дүгнэлт

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших “Шарангатай” нэртэй хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
ашиглах усны хэмжээ			
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	7050.0	м2	БОННУ-ний хуудас хуудас 33-т тоосжилтыг дарах усны тооцоо хэсэгт усалгааны замын нийт хэмжээ 7050м2 гэсэн байна.
Биологийн нөхөн сэргээлт хийхэд зарцуулах усны хэмжээ	12100.0	ш	БОННУ-ний хуудас 33-т төслийн үйл ажиллагааны явцад нийт 12.11 га талбай эвдрэлд өртөж байгаа ба биологийн нөхөн сэргээлтийн ажлын явцад усалгааг 7 хоногт 2 удаа хийх бөгөөд хүйтний улиралд болон тухайн нутгийн уур амьсгалаас шалтгаалж жилд нийт 12 удаа хийнэ
уурхайн үхлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ	25.9	м3	БОННУ-ний хуудас 91-т ордын талбайд 0.3-1 л/сек баримжаат усны нөөцтэй гэж тусгасан байна.

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Унд ахуй	0.4	34.56	Сумын худгаас зөврөөр хангадаг.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : **Төм смайл ХХК**
 Холбоо барих : **80112635**
 Нэмэлт мэдээлэл:

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
--------------------	------------------	-------------

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
---------------------	-------------------------------	------------------	--------------------------

10. Онцгой нөхцөл

Ус ашиглагч нь дараах зүйлсийг анхаарч үйл ажиллагаа явуулах:

Үүнд:

- Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох
- Голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглох
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх гэх мэт арга хэмжээ авч ажиллах
- Ундны усны худгуудад усны бичил элементийн шинжилгээ хийлгэх
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах.

Зураг 5. Ус ашиглуулах дүгнэлт

■ Ордын гидрогеологийн судалгаа хийлгэх

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	87	хоногт 1 хүн	0.08	180.0	Хоног	1,252.80	0.00	1,252.80
Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд ашиглах усны хэмжээ	200	ш	0.04	23.0	Удаа	184.00	0.00	184.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	7050	м2	0.002	23.0	Удаа	324.30	0.00	324.30
Биологийн нөхөн сэргээлт хийхэд зарцуулах усны хэмжээ	12100	ш	0.015	12.0	Удаа	2,178.00	0.00	2,178.00
уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ	26	м3	1.0	180.0	Хоног	4,662.00	0.00	4,662.00
Нийт						8,601.10	0.00	8,601.10

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м3	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м3 усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	1252.80	Газрын доорх ус	0.0	88.80	111,248.64	0.0	111,248.64
Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны арчилгаа усалгаанд ашиглах усны хэмжээ	184.00	Газрын доорх ус	0.0	74.00	13,616.00	0.0	13,616.00
Зам талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	324.30	Газрын доорх ус	0.0	185.00	59,995.50	0.0	59,995.50
Биологийн нөхөн сэргээлт хийхэд зарцуулах усны хэмжээ	2178.00	Газрын доорх ус	0.0	74.00	161,172.00	0.0	161,172.00
уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ	4662.00	Газрын доорх ус	0.0	888.00	4,139,856.00	0.0	4,139,856.00
Нийт	8,601.10				4,485,888.14		4,485,888.14

Зураг 6. Ус ашиглуулах дүгнэлт

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

Шүүрлийн усыг зам талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах шаардлагатай.

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

Усны тухай хуулийн 28.6, 29.1 дахь заалтуудыг үндэслэн Дундговь аймгийн Байгаль орчны газраас зөвшөөрөл авч гэрээ байгуулна.

Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахыг хориглодог болохыг анхаарах.

“Усны тухай” хуулийн 31.2-т зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч, жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, календарьчилсан графикийг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх.

Хаягдал бохир усанд улирал бүр 2-оос доошгүй холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээг хийлгэж, хариуг сав газрын захиргаанд ирүүлнэ.


Хаягдал ус хаяж зайлуулах цэг тогтоолгож, зөвшөөрөл авах шаардлагатай

Хаягдал усны дүгнэлтийг гаргуулах

Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай мэдээ тайлан, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээг 2025 оны 12 дугаар сарын 30-ны дотор “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газар”-ын захиргаанд ирүүлэх

Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцох.

Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагад даруй мэдэгдэж ажиллах.



Зураг 7. Ус ашиглуулах дүгнэлт



БАТЛАВ

“ТЕРРА ВИСТА” ХХК
ЗАХИРАЛ ХАСДА



УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025.12.30

Дугаар 03

Мандалговь хот

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны гаргасан 2025 оны 12 сарын 26–ний өдрийн E-2512-000169 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Байгаль орчны газрын даргын олгосон 2025 оны 12 сарын 30–ний өдрийн A/31 дугаартай ус ашиглах зөвшөөрөл олгох тухай тушаалыг тус тус үндэслэн:

Усны нөөц ашиглуулагчийг төлөөлж Дундговь аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчны газрын мэргэжилтэн Түмэнжаргал овогтой Эрдэнэзаяа Ус ашиглагчийг төлөөлж Дундговь аймгийн Өлзийт сум, 5968216 регистрийн дугаартай “ТЕРРА ВИСТА” ХХК-ны захирал ХАСДА нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Ус ашиглах зориулалт: MV–022056 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Шарангатай” нэртэй хайлуур жоншны ордыг ашиглах.
- 2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 8601,10 м³/жил
 - 2.2.1. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ: 1252,80 м³/жил,
 - 2.2.2. Биологийн нөхөн сэргээлтэд: 2178 м³/жил
 - 2.2.3. Зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус: 324,30 м³/жил
 - 2.2.4. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд модны усалгаанд ашиглах усны хэмжээ: 184 м³/жил
 - 2.2.5. Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ: 4662 м³/жил
- 2.3. Усны чанар, найрлага:
- 2.4. Усны эх үүсвэр: Сумын худгаас зөөврөөр хангадаг.

Зураг 8. Ус ашиглуулах гэрээ

Дөрөв. Бусад

- 4.1. Гэрээ нь талуудын гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.
- 4.4. Талуудын тохиролцоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
- 4.5 Үйл ажиллагаа тасалдсан тохиолдолд тухай бүр орон нутагтаа мэдэгдэж байх
- 4.6. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 - 4.6.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн
 - 4.6.2. Аль нэг тал татан буугдсан бол талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Ус ашиглуулагчийг төлөөлж:

БОГазрын мэргэжилтэн

 Т.Эрдэнэзаяа

Хаяг: Дундговь аймаг

Байгаль орчны газар

Утас: 88210582

Ус ашиглагчийг төлөөлж “Терра виста”

ХХК-ны гүйцэтгэх захирал Г. Хасда

 TERRA VISTA
Co., Ltd

Хаяг: СБД, 1-р хороо, Юнион бьулдинг,

1505А тоот

Утас: 99087855

Зураг 9. Ус ашиглуулах гэрээ

Огноо/Date: **2026.03.27 13:27:35**

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No: [001509371043](#)

Системийн огноо/System Date: **2026.03.27 13:27:35**

Дт/ From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/ Rate
	5400968628	Г*****Г ХАСДА	4,485,888.14 MNT	1.00
/ Дөрвөн сая дөрвөн зуун наян таван мянга найман зуун наян найман төгрөг Арван дөрвөн мөнгө /				
Кт/ To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр/Bank Name State Fund - Төрийн Сан		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name	4,485,888.14 MNT	1.00
	100080000944	Ду.Ус ашигласны төлбөр		

Гүйлгээний утга/Transaction description:
[5968216](#) Terra vista

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Сар/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Зураг 10. 2025 оны ус ашигласны төлбөр төлсөн баримт



Зураг 11. Уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан байдал



Зураг 12. Шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Шарангатай” хайлуур жоншны ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн хувьд уул техникийн нөхцлөөс шалтгаалан нөхөн сэргээлт хийгдэх боломжгүй учир 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 0.9 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж, хүлээлгэн өгсөн болно. Уг ажлын зардалд нийт 19.56 сая.төг зарцуулсан байна.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТАЛБАЙД НӨХӨН СЭРГЭЭЛТ
ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ

2026 оны 2 дугаар сарын 24-ны өдөр

1. Байршлын мэдээлэл																			
1.1	Аймаг, нийслэлийн нэр	Дундговь аймаг																	
1.2	Сум, дүүргийн нэр	Өлзийт сум																	
1.3	Газрын нэр	Шарангатай хайлуур жоншны ил уурхай																	
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын нэр																			
2.1	Аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	5968216																	
2.2	Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар	MV-022056																	
2.3	Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	21.4																	
2.4	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгжийн нэр, регистр	"Терра Виста" ХХК, 5968216																	
3. Өмнөх жилүүдэд тухайн тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн нөхөн сэргээлтийн ерөнхий мэдээ																			
3.1	Техникийн нөхөн сэргээлт	3.2 Биологийн нөхөн сэргээлт																	
	Талбайн хэмжээ (1,8 га)	Талбайн хэмжээ (га)																	
	Зардлын хэмжээ (төг)	Зардлын хэмжээ (төг)																	
4. 2025 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл																			
4.1	Техникийн нөхөн сэргээлт	4.2 Биологийн нөхөн сэргээлт																	
	Талбайн хэмжээ (0,9 га)	Талбайн хэмжээ (га)																	
	Зардлын хэмжээ (19,568,506 төг)	Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал																	
		Зардлын хэмжээ (төг)																	
5. Орон зайн мэдээлэл																			
5.1	Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг	5.2 Хэмжилт, зураглал Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр: Г. Мөнхдэлгэр Торсон фирмийн 2 долгионы GNSS-тай HIPER-II маркийн GPS -2 иж бүрдэл, COMNAV T30 – 2 ком Dron /PHANTOM 4 PRO V2.0 PPK-тай/-1 ком Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж Холбогдох утас: 86057711 Гарын үсэг:																	
5.3	Нөхөн сэргээлт хийсэн газрын солбилцол Жич. 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбилцол байна.	<table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th> <th colspan="2">Техник, биологи (доогуур зурах)</th> </tr> <tr> <th>Өргөрөг</th> <th>Уртраг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>45 11 20.99</td> <td>106 2 21.95</td> </tr> <tr> <td>2</td> <td>45 11 21.8</td> <td>106 2 15.44</td> </tr> <tr> <td>3</td> <td>45 11 23.05</td> <td>106 2 16.08</td> </tr> <tr> <td>4</td> <td>45 11 23.39</td> <td>106 2 22.13</td> </tr> </tbody> </table>	№	Техник, биологи (доогуур зурах)		Өргөрөг	Уртраг	1	45 11 20.99	106 2 21.95	2	45 11 21.8	106 2 15.44	3	45 11 23.05	106 2 16.08	4	45 11 23.39	106 2 22.13
№	Техник, биологи (доогуур зурах)																		
	Өргөрөг	Уртраг																	
1	45 11 20.99	106 2 21.95																	
2	45 11 21.8	106 2 15.44																	
3	45 11 23.05	106 2 16.08																	
4	45 11 23.39	106 2 22.13																	


Зураг 13. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээлгэн өгсөн акт

Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.	
6. Мэдээллийн сангийн бүртгэл	
Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.eic.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ. Жич: Мэдээллийн санд бүртгэгдээгүй тохиолдолд нөхөн сэргээлтийг хүлээн авсан актыг хүчинтэйд тооцохгүй.	
Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал: Захирал Г. Хасда	
Гарын үсэг:	
Огноо: 24.02.2026	
Нэмэлт мэдээлэл:	


Нөхөн сэргээлтийн ажил холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт:

Өмнөх жилүүдэд олборлолт хийсэн өөрийн талбайд 2025 оны БОМТ-ийн хүрээнд техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн байна. Мөн уурхай доторх хаягдлын овоолго бусад сул шороог түрж тухайн талбайг цэвэрлэсэн байна. Тус техникийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хүлээн авав.


АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:  С.Ган-Эрдэнэ /Засаг даргын орлогч/
(албан тушаал)

Гишүүд

 М.Ганчимэг /Байгаль орчны Хяналтын улсын байцаагч/
(албан тушаал)

Г. Басбат /4 дугаар Багийн Засаг дарга/
(албан тушаал)

 О.Энхтүвшин / Уурхайн дарга/
(нөхөн сэргээлт хийсэн байгууллагын төлөөлөл)

Зураг 14. Нөхөн сэргээлт хийсэн газрыг хүлээлгэн өгсөн акт

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг уурхай хаагдах үед хаалтын зардалд тусгаж өгсөн тул 2025 оны БОМТ-нд энэ чиглэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“ТЕРРА ВИСТА” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Зардал	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
1	Гал түймэр	Галын булан байрлуулах	Уурхайн тосгон	Ашиглалтын зардлаас	Уурхайд галын булан байрлуулсан



Зураг 15. Уурхайн талбай дахь галын булан

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Зардал, мян.төг	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Хог хаягдлын цэг, ангилан ялгах үйлдвэрийн талбай, кемп орчимд бохирдол үүсгэж болзошгүй	Хог хаягдлыг ялгах, зайлуулах, устгах, цэвэршүүлэх менежментийн төлөвлөгөөг мөрдөн ажиллах	1 000.0	Хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлж, хог хаягдлын гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлж байсан.
Нийт		1 000.0	

Өлзийт сумын ЗДТГ-тай “Хог хаягдлын төлбөрийн гэрээ”-г байгуулж, гэрээний дагуу хог хаягдал тээвэрлүүлсний зардал 300 000.0 төгрөгийг тушаасан болно.



ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025 он 09 дугаар сарын 26 өдөр

№ 06

Рашаант

Нэг . Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17-р зүйлийн 2,6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 40 тоот тогтоолыг тус тус үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

Хоёр. Гэрээ байгуулагч талууд

Нэг талаас Дундговь аймгийн Өлзийт сумын ЗДТГ-ыг төлөөлж Засаг дарга Адъяадорж овогтой Жавхлан нөгөө талаас Дундговь аймаг, Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, Юнион Биюулдинг А блок 1507 тоот хаягтай, 9011554003 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5968216 тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Өлзийт суман дахь “Өлзийт” нэртэй газарт ашиглалтын МУ-022056 тусгай зөвшөөрөл эзэмшигч “Терра Виста” ХХК-ны захирал Г.Хасда нар харилцан тохиролцож 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл энэхүү гэрээг байгуулав.

Гурав. Төлбөр тооцсон байдал

Өлзийт сумын ИТХ-ын 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 40 дүгээр тоот тогтоолын 25-д заасны дагуу уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжид хог хаягдал гаргасны 1 сарын төлбөрийг 148.000 төгрөгөөр тооцож ашиглалтын ажил явагдах 12 сард нийт 1.776.000 төгрөгөөр тооцов.

Дөрөв. Сумын ЗДТГ эрх, үүрэг

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

Тав. Иргэн ААН байгууллагын эрх үүрэг

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх.

Зураг 16. Өлзийт сумын ЗДТГ-тай байгуулсан “Хог хаягдлын гэрээ”

2. ААН байгууллага нь хог хаягдал гарсан төлбөрөө 2 дугаар улиралд багтаан ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлнө. /төрийн сан банк/
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх.
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах.
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх.
10. Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт ноогдуулсан төлбөрийн дагуу нэхэмжлэхээр төлбөрөө төлөх.

Зургаа. Гэрээний хариуцлага

1. Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ДУНДГОВЬ АЙМАГ ӨЛЗИЙТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА /.../ А.ЖАВХЛАН/
УТАС:88887527

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"ТЕРРА ВИСТА" ХХК-ны захирал
.../.../ Г.ХАСДА/
Утас: 99087865 VISTA
Co., Ltd
УЛААНБААТАР ХОТ
1115205061 @ 5968216

Зураг 17. Өлзийт сумын ЗДТГ-тай байгуулсан “Хог хаягдлын гэрээ”




Зураг 18. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх үйл явц



Зураг 19. Хог хаягдлын түр хадгалах ангиан ялгах цэг

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн хүрээнд агаар, ус, хөрсний шинжилгээг Дундговь аймгийн УЦУОШТ-ийн лабораторид өгөхөөр гэрээ байгуулж, хэмжилт, дээжлэлтийн ажлыг гүйцэтгүүлсэн болно.



Зураг 20. Хөрсний дээж авч буй байдал



Зураг 21. Агаарын чанарын хэмжилт болон усны дээж авч буй байдал

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ


ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2025/124
 Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ТЕРРА ВИСТА” ХХК
 Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Хандсүрэн /Лабораторийн инженер/
 Сорьцын төрөл, тоо : 1 Ус
 Хүлээн авсан огноо : 2025.10.02
 Сорьцын тодорхойлолт : Дундговь аймаг, Өлзийт сум
 Шинжилсэн огноо : 2025.10.02-08
 Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Сорьцын үзүүлэлтүүд	Ажилчдын ундны ус N 45°48'44.3" E 108°54'00.7"	MNS 0900:2018
1	Усан орчин /pH/	7.76	6.5-8.5
2	Цахилгаан дамжуулах чанар /EC/ μS/cm/	614	-
3	Кальцийн ион /Ca/ мг/л	76.4	100
4	Магнийн ион /Mg/ мг/л	35.5	30
5	Натри+Калийн ион /Na+K/ мг/л	22.3	-
6	Сульфатын ион /SO ₄ / мг/л	89.2	500
7	Хлорын ион /CL/ мг/л	95.7	350
8	Гидрокарбонатын ион /HCO ₃ / мг/л	208	-
9	Эрдэсжилт мг/л	533	-
10	Хатуулаг экв/л	7.1	7.0
11	Жинлэгдсэн бодис	51	-
12	Перманганатын исэлдэх чанар мг/л	4.5	-
13	Аммонийн азот /NH ₄ / мг/л	0.15	1.5
14	Нитритийн азот /NO ₂ / мг/л	0.004	1
15	Нитратийн азот /NO ₃ / мг/л	15.95	50
16	Эрдэс фосфор /PO ₄ ³ / мг/л	0.188	3.5
17	Фтор /F/ мг/л	0.83	0.7-1.5
18	Төмөр /Fe/ мг/л	0.03	0.3

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер
 Хянасан: Лабораторийн технологич инженер
 Баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга



Н.Түмэннаст
 О.Бат-Оюун
 Ш.Амарбилэг

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
 Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ


ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2025/135
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ТЕРРА ВИСТА” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Хандсүрэн /Лабораторийн инженер/
Сорьцын төрөл, тоо : Хөрс агрохими-2
Хүлээн авсан огноо : 2025.10.02
Сорьцын тодорхойлолт : Дундговь аймаг, Өлзийт сум
Шинжилсэн огноо : 2025.10.06-16
Хуудасны тоо : 1

Үр дүн

№	Цэгийн нэр	pH	Чийг %	Нитратын азот /NO ₃ / мг/кг	Сульфат /SO ₄ / мг/кг	Фосфор /P ₂ O ₅ / мг/кг	Амникийн азот /NH ₄ / мг/кг	Ялзмаг %
1	Кемп	8.22	0.55	66.86	38.2	49.85	18.52	0.54
2	Зам дагуу	7.88	0.28	56.90	39.0	34.41	7.17	0.89

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн технологич инженер *О.Бат-Оюун*
Хянаж баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга *Ш.Амарбилэг*



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УЦУОШТ-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар, он /№ : 2025/123
Сорьцыг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : “ТЕРРА ВИСТА” ХХК
Сорьцыг авсан хүний нэр, албан тушаал : Б.Хандсүрэн /Лабораторийн инженер/
Сорьцын төрөл, тоо : SO₂-3, NO₂-3, Нийт тоос-3
Хүлээн авсан огноо : 2025.10.02
Сорьцын тодорхойлолт : Дундговь аймаг, Өлзийт сум
Шинжилсэн огноо : 2025.10.03
Хуудасны тоо : 1
Үр дүн

№	Дээж авсан цэгийн нэр	Хүхэрлэг хий, SO ₂ мг/м ³	Азотын давхар исэл, NO ₂ мг/м ³	Нийт тоосны агууламж мг/м ³
1	Кэмп	0.001	0.030	0.464
2	Зам дагуу	0.029	0.016	0.074
3	Карьер	0.009	0.018	0.390
ЗДХ	MNS4585:2025	0.450	0.200	0.500

Шинжилгээ гүйцэтгэсэн: Лабораторийн инженер
Хянасан: Лабораторийн технологич инженер О. Бат-Оюун
Баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга




Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

АРАВ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байдал
Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангах	Уурхайн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, уурхайн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн, аюул осол эрсдэлгүй явуулах нөхцөлийг бүрдүүлсэн.
УАТөлөвлөгөө болон БОМТ-г боловсруулан батлуулах	УАТөлөвлөгөө болон БОМТ-г цаг хугацаанд нь боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан.
БОМТ-нд тусгасан ажлуудыг хэрэгжүүлэх	БОМТ-нд тусгагдсан нийт ажлуудыг уурхайн үйл ажиллагаандаа тусгаж, бүрэн хэрэгжүүлсэн.
Ажилчдыг ХХАА-ны хувцас хэрэгслээр бүрэн хангах	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.



Зураг 25. Ажилчдыг хувцас хэрэгслээр хангасан байдал



2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр №ДУЗДТГ/УУ2025091601

Мандалговь хот

Энэхүү гэрээг нэг талаас Дундговь аймгийг төлөөлж Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Лхагвабаатар, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай хамаарах Өлзийт сумыг төлөөлж Өлзийт сумын Засаг дарга А.Жавхлан /цаашид А тал гэх/, нөгөө талаас “Терра Виста” ХХК РД:5968216 /цаашид Б тал гэх/- ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Хасда нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээ нь Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулах, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Б тал нь аймаг, орон нутгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 1.3 Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт, 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.10 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 179-р тогтоол, болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Гэрээний хамрах хүрээг Дундговь аймгийн Өлзийт сумын Өлзийт нэртэй жоншны орд дээр MV-022056 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Терра Виста” ХХК-ийн уурхай (цаашид “төсөл” гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно.
- 2.2 Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:
 - 2.2.1 Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
 - 2.2.2 Байгаль орчныг хамгаалах,
 - 2.2.3 Ажлын байрыг нэмэгдүүлэх,
 - 2.2.4 Орон нутгийн жижиг дунд бизнесийн үйл ажиллагааг дэмжих,
 - 2.2.5 Соёлын өвийг хамгаалах,
 - 2.2.6 Боловсон хүчний бодлогыг дэмжих,

Зураг 26. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээ

- 2.3 Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 2.4 Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
- 2.5 Б тал нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.6 Б тал нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

ГУРАВ. НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН /А тал/ ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ерөнхий зүйлс

- 3.1.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана
- 3.1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх
- 3.1.3 Компани үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.4 Гэрээний хэрэгжилтэд холбогдох төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллана
- 3.1.5 Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээлнэ.
- 3.1.6 Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.
- 3.1.7 Хуулиар ноогдуулсан бүх татвар, төлбөр, хураамжийг төлүүлэх.

3.2 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр

- 3.2.1 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран ажиллана
- 3.2.2 Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.3 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

- 3.3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (БОМТ) хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийн хуваарь үнэлж, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн дараа жилийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх
- 3.3.2 Б талаас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулна.

3.4 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр

- 3.4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байрны талаарх мэдээллийг иргэдэд нээлттэй хэлбэрээр хүргэх;
- 3.4.2 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;
- 3.4.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;

Зураг 27. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээ

3.5 Мэдээлэх/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр

- 3.5.1 Иргэдэд төслийн хэрэгжилтийн талаар мэдээлэх;
- 3.5.2 Төслийн хэрэгжилтэд санал авах;
- 3.5.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймаг (сум, дүүрэг)-ийн ИТХ-аар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;
- 3.5.4 Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэй байгуулсан орон нутагтай хамтран ажиллах гэрээний талаар иргэдэд мэдээлэх;

ДӨРӨВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН /Б тал/ ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Ерөнхий зүйлс

- 4.1.1 Нутгийн захиргааны байгууллагатай хамтран байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллана;
- 4.1.2 Гамшиг, осол, гал түймэр гарсан үед шаардлагатай туслалцаа үзүүлнэ.
- 4.1.3 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын ИТХ-д хүргүүлнэ.

4.2 Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, орон нутгийн санд дэмжлэг үзүүлэх чиглэлээр

- 4.2.1 Энэхүү гэрээний хүчинтэй байх хугацаанд талууд тохиролцсоны үндсэн дээр Дундговь аймгийн орон нутаг хөгжлийн сангийн Төрийн сан банк дахь 100080052400 тоот дансанд 30,000,000 /гучин сая/ төгрөгийн дэмжлэгийг төвлөрүүлэх. /Дэмжлэгийн дүнгээс аймаг, сум, багт 60:30:10 хувиар бодож хувиарлана/
- 4.2.2 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9 дэх заалтад тусгасан энэ хуулийн 20.1-д заасны дагуу ногдуулсан албан татвараас 1 хувь хүртэл хөнгөлөлтөд хамаарах Нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив өгөх уг хуульд заасан чиглэлээр хамтран ажиллана.
- 4.2.3 Орон нутагт харъяалах үйл ажиллагааны бүх төрлийн татварыг орон нутагт төвлөрүүлэх арга хэмжээ авах.

4.3 Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр

- 4.3.1 Уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах
- 4.3.2 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн "Ашигт малтмал тээвэрлэлтийн нэгдсэн маршрут"-тай уялдуулан аймгийн Засаг даргаар батлуулж, маршрутын дагуу хуссан, замын ашиглалт, засварыг хариуцан тээвэрлэлт хийх
- 4.3.3 Өөрийн болон туслан гүйцэтгэгч компаниудын нэр дээр байгаа бүх тээврийн хэрэгсэл, чиргүүл, механизмуудыг орон нутгийн дугаар, гэрчилгээтэй болгох
- 4.3.4 Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийг орон нутагт бүртгэлтэй аж ахуй нэгжээр гүйцэтгүүлэх ба мэргэжлийн байгууллагаас ачааны болон дагалдах бичиг авч хэвших
- 4.3.5 Аж ахуй нэгж, байгууллага нь газрын гэрээ байгуулж ашиглах эрхийн гэрчилгээ авах
- 4.3.6 Баянжаргалан сумын нутаг дэвсгэрээр ашигт малтмал уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл бүр тус суманд байрших постод тогтоосон тарифаар төлбөр төлнө.

4.4 Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

Зураг 28. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээ

- 4.4.1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан БОМТ-нд хянаж, дүгнэх ажлын хэсэгт жил бүрийн 11 сарын 01-ний дотор тайлангаа ирүүлж дүгнэлтийг гаргуулах;

- 4.4.2 “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх;

4.5 Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр

- 4.5.1 Монгол ажилтнуудын 10-аас доошгүй хувь нь уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа тухайн сум, дүүргийн иргэд байх.

- 4.5.2 Гадаад ажилтны тоо нийт ажилтны 10 хувиас хэтрэхгүй байх;

- 4.5.3 Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төв, орон нутгийн захиргааны байгууллага энэ хуулийн 24.1-д заасан ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээ байгуулж хэрэгжүүлнэ. Дагалдан сургах ажилтны хувь хэмжээ нь тухайн ажил олгогчийн гадаад ажилтны 30 хувиас доошгүй байна.

- 4.5.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 43.1.1-д зааснаас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, 43.1.2-т зааснаас бага хэмжээгээр орон нутгийн иргэдийг авч ажиллуулсан ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.

- 4.5.5 ОН-ийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар ОН-ийн хөдөлмөрийн байгууллагатай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

- 4.5.6 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутгийн хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох (тухайн нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн,) өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;

4.6 Орон нутгийн жижиг дунд бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр

- 4.6.1 Орон нутгийн аж ахуйн нэгжийн санал болгосон бараа нь компанийн “Бараа, материал худалдан авах шалгуур үзүүлэлтүүд” болон үйлдвэрлэлийн хэрэгцээ, зориулалт, шаардлага, чанарын үзүүлэлтийг хангаж байгаа тохиолдолд дэмжиж ажиллана.

- 4.6.2 Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлах, компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

4.7 Мэдээлэх/ Санал авах/ Хэлэлцүүлэх чиглэлээр

- 4.7.1 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдэд тогтмол мэдээлэл өгч байх;

- 4.7.2 Тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТ

- 5.1 Гэрээний хэрэгжилт болон холбогдох хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаа талаар Аймаг, сумдын Засаг дарга, холбогдох төрийн байгууллагууд болох (АЗДТГ, БОГ, ГХБХБГ, ХХҮГ, Татварын газар, Цагдаагийн газар, Авто тээврийн газар) гэх мэт байгууллагууд болон нутгийн иргэдээр дамжуулан хяналт тавина.

Зураг 29. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээ

- 5.2 Гэрээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Засаг даргын орлогчоор ахлуулсан аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөл, тухайн сумын Засаг дарга, иргэний төлөөлөл гэсэн баг бүрэлдэхүүн гэрээний дагуу хянаж, дүгнэнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 6.1 Талууд гэрээний тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар улиралд багтаан дүгнэнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 7.1 Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.
7.2 Энэхүү гэрээг биелүүлэхэд талууд санаачлага гаргаж ажиллана.
7.3 Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.
7.4 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
8.2 Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД

- 9.1 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
9.2 Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
9.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
9.4 Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б. ДХАГВАБААТАР

“ТЕРРА ВИСТА” ХХК-ИЙН ҮЙЛЧИЙН ЦЭГТГЭХ
ЗАХИРАЛ
УТАС: 99087855
ХАЯГ: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
22-р хороо, Төгөл хус 12-01

ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.ЖАВХЛАН

Зураг 30. Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх чиглэлээр хамтран ажиллах гэрээ



Огноо/Date: 2026-03-26 20:18:08

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 26076358

Гүйлгээний дугаар /Poid: 0

Системийн огноо/System Date: 2025-12-10 15:21:44

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5400968628	ГАНХУЯГ ХАСДА	30,000,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No МОГУМНУВ	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN470090 100080052400	Нэр/Name Ду.ОНХөгжлийн сан	30,000,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ДУЗДТГЛУУ2025091601 ТЕРРА ВИСТА 5968216

Зураг 31. Хамтран ажиллах гэрээний биелэлт

**АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулан БОУАӨЯ-ны цахим системд цаг хугацаанд нь илгээж, Дундговь аймгийн БО-ны газарт хүргүүлсэн болно.

ДҮГНЭЛТ

Манай компани нь 2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Тоосжилт ихтэй үед зам усалгааг тогтмол хийж байсан.
- ✓ Уурхайн талбайд тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 100 ш суулгац авч уурхайн талбай орчимд суулгасан.
- ✓ Уурхайн талбайд галын булан байгуулсан.
- ✓ Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 0.9 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж, хүлээлгэн өгсөн.
- ✓ Хог хаягдлын гэрээ байгуулж, гэрээний дагуу тээвэрлүүлж байсан.
- ✓ Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан.
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд агаар, хөрс, усны шинжилгээ авч лабораторид шинжлүүлсэн.

2025 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөөр хийгдэх ёстой ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн болно.